



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/70/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Дорноговь аймаг)

2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 7052-2734, Цахим хаяг:
dornogovi@audit.gov.com

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 7052-3020 Цахим хаяг:

Аудитор: Э.Вандандулам

Утас: 99058176 Цахим хаяг:
mnbaudithhk@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

(«Au_code»)

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
5 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

2019.02.27 № 1-6/232
тгнай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРУИНАА

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Эрдэнэцэцэг-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019-01-25-наас 2019-01-27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019-02-15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019-01-25, 2019-02-02-ны өдрийн 18 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль нь Харилцааг эрхэмлэн, оролцоог дэмжиж, бүтээлч хандлагатай хүмүүнлэг иргэнийг төлөвшүүлнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрмээр Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын

хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 1 хувиар сонгов.

Нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсвийн шууд захирагч төсвийн зарцуулалтыг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах үүрэгтэй тул анхаарах чухал үзүүлэлт гэж тодорхойлсонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль 2018 оны *Нийт зардал* 2,102,901.7 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 21,029.02 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1% хувиар тооцсон нь 21,029.0 мянган төгрөгөөс доош дүнгээр гарсан ажил гүйлгээ нь тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлөхгүй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	2,128.20	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	7,074.9	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	9,203.1	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Балансын данстай холбоотой асуудал:

1. Тухайн байгууллагын тайлант хугацааны санхүүжилтийн зардлаас хэмнэгдсэн 6,705,018 төгрөгийг Нийгмийн даатгал, татварын байгууллагуудад шилжүүлж зориулалт бусаар зарцуулан авлага үүсгэсэн байна.
2. Өмнөх онд үүссэн Татварын албанд Хувь хүнээс суутгасан орлогын албан татварт шилжүүлсэн 369,864 төгрөгийн авлагыг барагдуулаагүй ажилласан.

Энэ нь үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6.4.1, 6.4.8, 39.4.2 заалтуудын төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, өр, авлага үүсгэхгүй ажиллах, тус хуулийн 7.7-д төсвийн жил дуусахад ... төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт өгч, биелэлтийг 2019 оны 03-р сарын 25-ний дотор Дорноговь аймгийн Төрийн аудитын байгууллагад ирүүлэх

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Орон тоо, цалингийн тооцоолол, холбогдох тайлагнал, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх,

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 11 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,197,484.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,197,251.6 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь 237,8 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн нь тогтмол зардлын хэмнэлтээс шалтгаалжээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100% хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургууль нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт

1. Бэлтгэн нийлүүлэгчдийн нийлүүлсэн бараа материалын нэр төрөл шаардахаар олгосон зарим нэр төрлийн бүтээгдэхүүнээс зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 13.6, 20.1.4-д заалтыг зөрчиж байна.
2. Бэлтгэн нийлүүлэгчдээс бараа материалыг худалдан авахдаа ебаримт аваагүй ажилласан нь НББ тухай хуулийн 13 дүгээр зүйл Сангийн сайдын 2017,12,05 ны 347 тоот тушаалаар батлагдсан НХМ-ТМ-5-аар гүйлгээ хийгдэхгүй байна байна.

Эрсдэл

Төсвийн хөрөнгийг илүү зарцуулах, анхан шатны баримт дутуу бүрдэх

Зөвлөмж

1. Цаашид бэлтгэн нийлүүлэгчдийн бичсэн зарлагын баримт шаардахаар олгогдсон бараа материалын нэр төрөлтэй нийцэж байгаа эсэхэд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллах
2. Бэлтгэн нийлүүлэгчдээс бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа ебаримт авч, бүрдүүлж ажиллах

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн Б.Эрдэнэцэцэг

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг мөрдөн ажиллана.

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

ӨМНӨХ АУДИТ БОЛОН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ, ҮР ДҮН

Илрүүлэлт

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгагдсан орлогыг анхан шатны баримттай тулган шалгахад 2018-02-09-ний өдрийн 82,364,600 төгрөгийн орлогын гүйлгээ 2 дахин бичигдэж үндсэн дансны үлдэгдэл энэ дүнгээр илэрхийлэгдсэн байна. Тухайн байгууллагын дансны хуулгын эцсийн үлдэгдэл төсвийн зарцуулалтын эрхийн баталгааны хуудасны дүнгээс зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 заалтыг зөрчсөн.
2. Эцэг эхчүүдийн хандивын хөрөнгөөр бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаж нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 25.7 заалт, УСНББОУС 23-ийн 93-103 хэсгийг зөрчсөн байна.

Эрсдэл

Төсөвт байгууллагын анхан шатны баримт дутуу бүрдэх, хөрөнгө, нэмэлт орлогыг дутуу бүртгэх

Зөвлөмж

1. Цаашид харилцах дансны хуулгыг төрийн сангаар баталгаажуулж санхүүгийн тайланд тусгаж байх.
2. Төгсөгч, эцэг эхчүүд, бусад холбоотой талаас хандивласан хөрөнгийг холбогдох стандарт, хууль, дүрэм журмыг баримтлан бүртгэж, санхүүгийн тайланд тусгаж, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллах

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн захирал Б.Эрдэнэцэцэг

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг мөрдөн ажиллана.

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт

1. Санхүүгийн тайланд тусгагдсан авлага өглөгийн үлдэгдлийг анхан шатны баримттай тулган шалгахад 2,128,202 төгрөгийн ажилчдаас авах авлага үүссэн бөгөөд өмнөх жилд олгосон нэмэгдлээс НДШ суутгах авлагыг барагдуулаагүй ажилласан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар ашиглагдах

Зөвлөмж

Цаашид төсвийг зохистой удирдаж авлага өглөг үүсгэхгүй ажиллах

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын тавдугаар сургуулийн Б.Эрдэнэцэцэг

Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрөөгүй

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 25 тоот албан бичгээр хүлээн зөвшөөрөөгүй тухайгаа ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6-р сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ч.АРИУНАА

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Ц.ЛҮНДЭГМАА

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Э.ВАНДАНДУЛАМ

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>121,469,643.92</u>	<u>109,924,382.77</u>
33	АВЛАГА	4,638,173.60	9,203,084.93
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,598,592.60	2,128,202.00
335	Бусад авлага	2,039,581.00	7,074,882.93
3351	Байгууллагаас авах авлага	2,039,581.00	7,074,882.93
35	БАРАА МАТЕРИАЛ	116,831,470.32	100,721,297.84
351	Түүхий эд материал	64,000.00	00.00
35130	Эм боох материал	64,000.00	00.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,000,000.00	1,000,000.00
354	Хангамжийн материал	115,767,470.32	99,721,297.84
35410	Бичиг хэргийн материал	939,500.00	1,845,550.00
35420	Аж ахуйн материал	35,507,559.94	37,523,811.94
35470	Бусад хангамжийн материал	79,320,410.38	60,351,935.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,521,743,404.75</u>	<u>2,194,853,639.08</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,521,743,404.75	2,194,853,639.08
392	Биет хөрөнгө	2,521,387,154.83	1,990,664,139.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,550,807,973.00	1,678,392,225.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-268,291,493.69	00.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	266,447,419.40	284,042,019.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-161,920,987.65	-206,340,529.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	177,443,085.35	179,738,223.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-77,408,989.78	-93,774,719.36
39209	Зам, гүүрийн байгууламж	00.00	94,984,563.06
39217	Ном	34,310,148.20	53,622,357.68
393	Биет бус хөрөнгө	356,249.92	204,189,499.84
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-993,750.08	-1,112,500.16
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,643,213,048.67</u>	<u>2,304,778,021.85</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,068,568.64	00.00
413	Өглөг	5,068,568.64	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,638,144,480.03</u>	<u>2,304,778,021.85</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,638,144,480.03	2,304,778,021.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,294,688,057.09	2,498,640,057.09
51101	Өмч: - төрийн	2,294,688,057.09	2,498,640,057.09
512	Хуримтлагдсан үр дүн	343,456,422.94	-817,617,875.04
51210	Өмнөх үеийн үр дүн	343,456,422.94	32,529,251.58
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-850,147,126.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	623,755,839.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,643,213,048.67</u>	<u>2,304,778,021.85</u>

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	618,218,629.00	1,252,754,552.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	42,022,952.48
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	42,022,952.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	42,022,952.48
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,290,743.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	38,732,209.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	618,218,629.00	13,247,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	615,014,600.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	615,014,600.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	1,197,484,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,204,029.00	13,247,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,124,194.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00	13,247,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,279,835.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	668,979,358.35	1,313,175,312.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	668,979,358.35	1,313,175,312.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	654,182,364.35	1,202,871,692.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	393,076,278.40	685,501,213.85
210101	Үндсэн цалин	393,076,278.40	485,508,329.85
210102	Нэмэгдэл	00.00	149,329,471.00
210104	Урамшуулал	00.00	50,663,413.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,519,659.00	141,770,140.98
210201	Тэтгэврийн даатгал	27,804,263.00	131,472,046.98
210202	Тэтгэмжийн даатгал	3,773,053.00	3,374,123.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,338,215.00	2,683,879.00
210204	Ажилгүйдлийн даатгал	782,194.00	496,945.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,821,934.00	3,743,147.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,842,182.00	211,963,667.00
210301	Гэрэл, цахилгаан	5,019,931.00	8,183,626.00
210302	Түлш, халаалт	105,673,329.00	183,218,374.00
210303	Цэвэр, бохир ус	9,148,922.00	20,561,667.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,257,683.50	3,025,748.10
210401	Бичиг хэрэг	599,650.00	305,840.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	753,997.50	918,597.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	282,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,664,036.00	1,419,311.10
2105	Нормативт зардал	21,584,405.00	800,000.00
210502	Хоол, хүнс	20,956,800.00	00.00

ЕБ-ын 5 дугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	627,605.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,689,808.00	1,735,461.00
210604	Урсгал засвар	184,938.00	1,735,461.00
2107	Томилолт, зочны зардал	100,000.00	738,800.00
210702	Дотоод албан томилолт	100,000.00	738,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	410,956.00	2,827,249.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	410,956.00	2,827,249.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,701,392.45	154,509,412.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	979,262.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,262,507.00	12,040,602.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,438,885.45	141,489,548.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,796,994.00	110,303,620.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,796,994.00	110,065,750.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	132,000.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,124,194.00	50,275,650.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	46,851,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,540,800.00	12,938,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	237,870.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	237,870.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-50,760,729.35</u>	<u>-60,420,759.69</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	789,726,366.93
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	16,786,874.48
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	772,939,492.45
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-789,726,366.93
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-50,760,729.35</u>	<u>-850,147,126.62</u>

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	618,218,629.00	1,214,022,343.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	3,290,743.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	3,290,743.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	3,290,743.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,290,743.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	618,218,629.00	1,210,731,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	1,197,484,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,204,029.00	13,247,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	800,000.00	13,247,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	601,385,197.50	1,189,265,730.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	601,385,197.50	1,189,265,730.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	566,887,597.50	1,078,962,110.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	392,900,993.00	705,169,350.00
210101	Үндсэн цалин	288,087,215.00	459,745,450.00
210102	Нэмэгдэл	91,827,000.00	176,924,200.00
210104	Урамшуулал	12,986,778.00	68,499,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,843,800.00	133,193,700.00
210201	Тэтгэврийн даатгал	43,843,800.00	127,673,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	2,165,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,732,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	433,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,189,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110,849,600.00	210,056,321.00
210301	Гэрэл, цахилгаан	5,400,000.00	8,183,626.00
210302	Түлш, халаалт	102,703,226.00	179,872,695.00
210303	Цэвэр, бохир ус	2,746,374.00	22,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,592,420.50	4,511,050.00
210401	Бичиг хэрэг	528,500.00	799,350.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	753,997.50	1,030,000.00
210404	Ном, хэвлэл	20,000.00	500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	282,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,049,923.00	1,799,700.00
2105	Нормативт зардал	00.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,985,739.00	3,216,387.52
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,520,133.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,465,606.00	1,716,387.52
2107	Томилолт, зочны зардал	100,000.00	738,800.00

ЕБ-ын 5 дугаар сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	100,000.00	738,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,667,951.00	2,415,354.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,667,951.00	2,415,354.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,947,094.00	18,861,147.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,159,394.00	3,410,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,787,700.00	15,451,147.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,497,600.00	110,303,620.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,497,600.00	110,065,750.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,956,800.00	50,275,650.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	46,851,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,540,800.00	12,938,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	237,870.10
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	237,870.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>16,833,431.50</u>	<u>24,756,612.48</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	24,756,612.48
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	24,756,612.48
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	24,756,612.48
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	24,756,612.48
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-24,756,612.48</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	16,833,431.50	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,833,431.50	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,294,688,057.09	00.00	-18,536,395.82	00.00	2,276,151,661.27
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-338,587.26	00.00	-338,587.26
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,294,688,057.09	00.00	-18,874,983.08	00.00	2,275,813,074.01
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	406,918,037.75	00.00	406,918,037.75
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,294,688,057.09	00.00	343,456,422.94	00.00	2,638,144,480.03
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-310,927,171.36	00.00	-310,927,171.36
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,294,688,057.09	00.00	32,529,251.58	00.00	2,327,217,308.67
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	623,755,839.80	00.00	00.00	623,755,839.80
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	203,952,000.00	00.00	-850,147,126.62	00.00	-646,195,126.62
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	-817,617,875.04	00.00	2,304,778,021.85

